

130



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 15 өдөр

Дугаар 183

Номгон

Гэрэлт хөшөө байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 20.1.14 дэх заалт, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр зарлигийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойд зориулж тус аймгийн Бөмбөгөр сумын нутаг Өлзийт хайрханы (одоогийн Бөмбөгөр хайрхан) өвөрт Баянхонгор аймгийг Говь-Бөмбөгөр аймаг нэртэй байгуулагдаж байсан газарт Гэрэлт хөшөө байгуулах санаачилгыг дэмжсүгэй.

2. Түүхийн дурсгалт Гэрэлт хөшөө байгуулахтай холбогдуулан хөшөөний загвар зохиох нээлттэй уралдааныг 30 хоногийн хугацаатай зарлаж сонгон шалгаруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх бүтээлийг сонгон шалгаруулах ажлын хүрээнд аймаг байгуулагдаж байсан түүхийн талаарх баримт, судалгаа, түүх домог, газрын байршлыг сонгосон учир шалтгаан, шашны уламжлалт зан үйлийн талаарх мэдээллүүдийг сайтар судлан, хөшөөг орчин цагийн хөгжилтэй уялдуулан он цагийн түүхэн дурсгалын зэрэгцээ аялал жуулчлал, тохижилт үйлчилгээ, гоёл чимэглэлийн өнгө дизайнтай байгуулах талаар санаачилгатай ажиллахыг ажлын хэсэг (Т.Норов)-т үүрэг болгосугай.


4. Гэрэлт хөшөө байгуулах уралдаанд шалгарсан бүтээлийг урамшуулах зардалд шаардагдах 1,0 сая (нэг сая) төгрөгийг холбогдох зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д үүрэг болгосугай.



0121260

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 15-ны
өдрийн 123 дугаар тогтоолын хавсралт



ГЭРЭЛТ ХӨШӨӨНИЙ ЗАГВАР ЗОХИОХ НЭЭЛТТЭЙ
УРАЛДААНЫГ ЗАРЛАЖ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Т.Норов (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Р.Пүрэвсүрэн (Аймгийн Түүх угсаатны зүй-Байгалийн
музейн захирал)

Гишүүд: Г.Энхбаяр (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч,
Аймгийн Засаг даргын орлогч)

Х.Нарантунгалаг (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Б.Наранбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Содномсамдан (Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын
мэргэжилтэн)

С.Хүрэлхуяг (Аймгийн Ерөнхий архитектор)

Г.Магнайбаяр (Бөмбөгөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)

М.Мөнх-Эрдэнэ (Бөмбөгөр сумын Засаг дарга)